


## МӨНГӨНИЙ ТОЙМ

(2016 оны 5 дугаар сар)



## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


|  | 2013         | 2014     | 2015     | 2016     |          |          |          |          |
|--|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
|  | 12-р сар     | 12-р сар | 12-р сар | 1-р сар  | 2-р сар  | 3-р сар  | 4-р сар  | 5-р сар  |
| <b>M2 мөнгө, тэрбум ₮</b>  | 9,454.9      | 10,635.8 | 10,050.2 | 9,850.8  | 10,015.0 | 10,113.7 | 10,518.7 | 10,659.5 |
| сарын өөрчлөлт, %  | 3.9          | 7.1      | 2.5      | -2.0     | 1.7      | 1.0      | 4.0      | 1.3      |
| жилийн өөрчлөлт, %   | 24.2         | 12.5     | -5.5     | -4.5     | -2.1     | 2.1      | 8.4      | 8.3      |
| <b>Бусад хадгаламж, тэрбум ₮</b>   | 7,361.7      | 8,819.1  | 8,364.8  | 8,242.7  | 8,492.0  | 8,530.0  | 8,835.2  | 8,916.5  |
| сарын өөрчлөлт, %  | 1.2          | 7.0      | 1.4      | -1.5     | 3.0      | 0.4      | 3.6      | 0.9      |
| жилийн өөрчлөлт, %   | 27.4         | 19.8     | -5.2     | -5.6     | -1.8     | 0.9      | 7.4      | 9.3      |
| <b>Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮</b>  | 841.1        | 809.7    | 706.7    | 713.8    | 655.5    | 658.6    | 745.1    | 788.3    |
| сарын өөрчлөлт, %  | 4.6          | 5.3      | -0.5     | 1.0      | -8.2     | 0.5      | 13.1     | 5.8      |
| жилийн өөрчлөлт, %   | 1.5          | -3.7     | -12.7    | -2.5     | -15.5    | -6.3     | 1.4      | -0.7     |
| <b>Нөөц мөнгө, ₮</b>   | 3,335.5      | 3,426.5  | 2,459.6  | 2,310.7  | 2,308.4  | 2,360.7  | 2,987.8  | 3,204.7  |
| сарын өөрчлөлт, %  | 18.1         | 27.9     | 17.9     | -6.1     | -0.1     | 2.3      | 26.6     | 7.3      |
| жилийн өөрчлөлт, %   | 54.0         | 2.7      | -28.2    | -19.2    | -16.0    | -4.4     | 35.5     | 32.9     |
| <b>Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>                                       | 12,582,666.8 | 16,599.5 | 17,932.8 | 18,074.8 | 18,150.2 | 18,430.3 | 18,309.0 | 18,130.2 |
| сарын өөрчлөлт, %  | -0.6         | 2.7      | 0.5      | 0.8      | 0.4      | 1.5      | -0.7     | -1.0     |
| жилийн өөрчлөлт, %   | 75.0         | 31.2     | 10.9     | 8.9      | 11.1     | 11.5     | 7.3      | 6.1      |
| <b>Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮</b>                                     | 10,764.2     | 12,502.5 | 11,695.8 | 11,783.0 | 11,628.2 | 11,827.5 | 11,629.3 | 11,437.6 |
| сарын өөрчлөлт, %  | -0.5         | -1.2     | -1.6     | 0.7      | -1.3     | 1.7      | -1.7     | -1.6     |
| жилийн өөрчлөлт, %   | 54.0         | 16.1     | -6.5     | -2.5     | -4.5     | -3.6     | -5.4     | -6.1     |
| <b>Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар</b>                                     | 5.26         | 5.00     | 7.44     | 7.59     | 7.84     | 8.18     | 9.23     | 9.29     |
| <b>Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар (Хадгаламж, Зоос банкныг хассанаар)</b> | 2.48         | 3.10     | 5.53     | 5.69     | 5.91     | 6.30     | 7.35     | 7.38     |
| <b>Хуу</b>   |              |          |          |          |          |          |          |          |
| Хадгаламжийн ЖДХ   | 12.1         | 12.5     | 13.3     | 13.5     | 13.5     | 13.3     | 13.4     | 13.2     |
| Зээлийн ЖДХ*   | 17.4         | 19.5     | 19.1     | 19.7     | 20.1     | 19.7     | 20.0     | 19.1     |
| Монголбанкны ҮТХ зээлийг оруулсан ЖДХ*   | 14.9         | 16.9     | 18.3     | 19.1     | 19.1     | 17.9     | 17.5     | 17.2     |
| Ипотекийн зээлийн ЖДХ  | 9.90         | 9.9      | 8.8      | 10.0     | 9.2      | 8.8      | 8.2      |          |
| ТБҮЦ-ны ЖДХ  | 10.5         | 12.1     | 13.0     | 12.6     | 12.0     | 12.0     | 12.0     | 10.6     |
| Бодлогын хүү   | 10.5         | 12.0     | 13.0     | 12.0     | 12.0     | 12.0     | 12.0     | 10.5     |
| БХЗ-ын ЖДХ   | 8.9          | 12.2     | 11.8     | 11.8     | 11.4     | 12.6     | 12.7     | 12.3     |
| <b>Инфляци</b>   |              |          |          |          |          |          |          |          |
| <b>Улаанбаатар хотын инфляци</b>   |              |          |          |          |          |          |          |          |
| сарын  | 1.7          | 0.6      | -0.2     | 0.4      | 0.8      | 0.3      | 1.5      | 0.1      |
| оны эхнээс   | 11.2         | 10.7     | 1.1      | 0.4      | 1.2      | 1.5      | 3.1      | 3.2      |
| жилийн   | 11.2         | 10.7     | 1.1      | 1.0      | 1.6      | 1.1      | 1.9      | 1.8      |
| <b>Суурь инфляци</b>   |              |          |          |          |          |          |          |          |
| сарын  | 1.3          | 0.4      | -0.1     | -0.4     | -0.4     | -0.4     | 0.1      | -0.2     |
| оны эхнээс   | 12.1         | 12.6     | 4.8      | -0.4     | -0.7     | -1.1     | -1.0     | -1.2     |
| жилийн   | 12.1         | 12.6     | 4.8      | 4.0      | 3.5      | 3.1      | 3.2      | 3.1      |
| <b>Улсын инфляци</b>   |              |          |          |          |          |          |          |          |
| сарын  | 0.7          | 0.8      | -0.2     | 0.5      | 0.7      | 0.5      | 1.4      | 0.1      |
| оны эхнээс   | 11.9         | 11.0     | 1.9      | 0.5      | 1.2      | 1.7      | 3.1      | 3.3      |
| жилийн   | 11.9         | 11.0     | 1.9      | 1.7      | 2.0      | 1.7      | 2.1      | 1.8      |

\* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

### Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 1.3 хувь, оны эхнээс 6.1 хувь, өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар өсч 10659.5 тэрбум төгрөг болжээ.


Мөнгөний нийлүүлэлтийн 52.3 хувийг төгрөгийн хадгаламж, 20.6 хувийг гадаад валютын хадгаламж, 11.5 хувийг гадаад валютын харилцах, 10.7 хувийг төгрөгийн харилцах, 4.9 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Тайлант сард гадаад валютын хадгаламжийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сарынхаас 10.7 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 0.4 нэгж хувиар өссөн бол төгрөгийн харилцахынх 3.7 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 7.6 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 28.9 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж 115 тэрбум, төгрөгийн харилцах 46.1 тэрбум, гадаад валютын хадгаламж 28.5 тэрбум, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 13.5 тэрбум төгрөгөөр өссөн бол гадаад

валютын харилцах 62.2 тэрбум төгрөгөөр буурчээ.



Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар өссөний 3.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 1.1 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.5 нэгж хувийг төгрөгийн харилцах тус тус бүрдүүлсэн байна.


### Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 1.9 хувь буюу 143.5 тэрбум төгрөгөөр өсч 7772.9 тэрбум төгрөг болов.



Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 2.8 хувь буюу 128.5 тэрбум төгрөгөөр, өмнөх

оны мөн үеэс 18.2 хувь буюу 723.8 тэрбум төгрөгөөр өсч 4695.2 тэрбум төгрөгт хүрчээ. Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 1.5 хувь буюу 13.4 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 28.5 хувь буюу 351.1 тэрбум төгрөгөөр буурч 880.7 тэрбум төгрөг болжээ.



Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 1.3 хувь буюу 28.5 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 14.5 хувь буюу 278.7 тэрбум төгрөгөөр буурч 2197 тэрбум төгрөг болжээ.




Нийт хадгаламжийн 71.7 хувь нь төгрөгийн, 28.3 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 11.5 хувийг эзэлж буй төгрөгийн харилцах өмнөх сараас 3.9 хувь буюу 46.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 4.3 хувь буюу 50.7 тэрбум төгрөгөөр өсч 1222 тэрбум төгрөг болсон бол 10.7 хувийг эзэлж буй валютын харилцах өмнөх сараас 5.2 хувь буюу 62.2 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 10.5 хувь буюу 109 тэрбум төгрөгөөр өсч 1143.5 тэрбум төгрөг болжээ.

### Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 7.1 хувь, өмнөх оны мөн үеэс 21.8 хувиар өсч -2460 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх сараас 4.2 хувь, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өсч 8199.6 тэрбум төгрөг болов.



### Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 7.3 хувь, өмнөх оны мөн үеэс мөн 32.9 хувиар өсч 3204.7 тэрбум төгрөг болжээ. Тайлант сард Төв банк дахь харилцах, хадгаламж 7.7 хувь буюу 173.6 тэрбум төгрөг, банкуудын касс 12.7 хувь буюу 29.8 тэрбум төгрөг, хадгаламжийн

байгууллагаас гадуурх мөнгө 2.7 хувь буюу 13.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 8.3 нэгж хувиар өсч 75.5 хувь, банкуудын кассын эзлэх хувь 3 нэгж хувиар буурч 8.3 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 5.2 нэгж хувиар буурч 16.3 хувьтай байна.


**Зээл**

Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сараас 0.7 нэгж хувь, өмнөх оны мөн үеэс 9.2 нэгж хувиар буурч жилийн 6.5 хувийн өөрчлөлттэй байна.


Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сарынхаас 1 хувь буюу 178.8 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 6.5 хувь буюу 1099.8 тэрбум төгрөгөөр өсч 18.1 их наяд төгрөг болжээ. Үүний 63.1 хувь буюу 11.4 их наяд төгрөгийг хадгаламжийн байгууллагуудын, 36.9 хувь буюу 6.7 их наяд

төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл бүрдүүлж байна.

Санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээл өмнөх сараас 1.1 хувь буюу 77.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 7 хувь буюу 482.2 тэрбум төгрөгөөр өсч 7392.9 тэрбум төгрөгт, хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 2.5 хувь буюу 175.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 0.8 хувь буюу 54.5 тэрбум төгрөгөөр буурч 6837 тэрбум төгрөг болжээ.



Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 40.8 хувь нь иргэд, 37.7 хувь нь хувийн хэвшил, 21.5 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.



Нийт зээлийн үлдэгдлийн 86 хувийг хэвийн зээл, 8.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.9 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувь, чанаргүй зээлийнх 1.5 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн байгууллагуудын зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 9.3 хувь байгаа бөгөөд татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.4 хувийг эзэлж байна.

### Картын зээл

Банкуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон картын зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 1.9 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл 5-р сарын байдлаар 210.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буюу 25.7 тэрбум төгрөгөөр буурчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа

бөгөөд өмнөх сараас 0.1 хувиар буюу 0.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Картын зээлийн 89.5 хувь нь хэвийн, 3.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.3 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 93.4 хувь нь төгрөгөөр, 6.6 хувь нь валютаар олгогдсон байна.

### Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2016 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар бага буюу жилийн 10.59 хувьтай байна. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч жилийн 19.1<sup>1</sup> хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурч жилийн 11.7 хувь болжээ.

<sup>1</sup> Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол


төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 17.2 хувь байна.



Төгрөгийн болон гадаад валютын харилцахын хүү харьцангуй тогтвортой байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсч жилийн 13.2 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч жилийн 6.5 хувь болов.

## Мөнгөний зах

2016 оны 5 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 648.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.29 хувь байна.



2016 оны 3 сарын 30-ны өдрөөс 2016 оны 5 сарын 26-ны өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 1016.5 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд дунджаар 456.5 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Тодруулбал, банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 978.6 тэрбум төгрөг, валютын нөөцөд дунджаар 1272.7 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

## Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны 5 дугаар сарын эцэст 1988.53 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 81.2 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2005.96 төгрөг байв. Тайлант сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2213.13, хятадын юаньтай харьцах ханш 301.99, японы иентэй харьцах ханш 17.89 төгрөг болжээ.



## Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2016 оны 5 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 3.3 хувь, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өссөн бол Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс

өмнөх сараас 0.1 хувь, оны эхнээс 3.2 хувь, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өсчээ. Суурь инфляци тухайн сард -0.2 хувь, оны эхнээс -1.2, жилийн 3.1 хувьтай байв.

**Тухайн сард** Улаанбаатар хотын инфляци 0.1 хувиар өссөн нь хүнсний барааны үнэ 0.7 хувиар өсч, хүнснээс бусад барааны үнэ 0.2 хувиар буурсантай холбоотой.

Хүнсний барааны үнийн өсөлтөд хүнсний ногооны үнэ 1.9 хувь, махны үнэ 1.6 хувиар өсч, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 0.4 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд амбулаторийн үйлчилгээ 4.5 хувь, орон сууцны түрээс 2.7 хувь, гэр ахуйн тавилга, барааны үнэ 0.9 хувиар өсч, нүүрсний үнэ 11.5 хувиар буурсан нь нөлөөлөв. Тухайн сарын инфляцийн 0.2 хувийг мах, 0.05 хувийг орон сууцны түрээс, 0.04 хувийг эмнэлгийн үйлчилгээ, 0.02 хувийг гэрийн тавилга, -0.33 хувийг нүүрсний үнийн өөрчлөлт эзэлжээ.



Боловсролын бүлгийн **жилийн инфляци** 23.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийнх 9.1 хувь, гэр ахуйн бараа, тавилгын бүлгийнх 3.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 1.9 хувь, зочид буудал,

дотуур байрны үйлчилгээний бүлгийнх 1.8 хувь байна.

Харин орон сууц, цахилгаан, түлшний үнэ өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 1.8 хувь, тээврийн үнэ 1.5 хувь, хүнсний барааны үнэ 0.9 хувиар буурчээ.

Жилийн инфляцийн 93.8 хувийг боловсролын үйлчилгээ, 14.6 хувийг эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, 8.6 хувийг хувцас, бөс бараа, 5.8 хувийг гэр ахуйн бараа, тавилга, -14.8 хувийг хүнсний бараа, -13.8 хувийг орон сууц, цахилгаан, түлш, -8.6 хувийг тээврийн үнийн өөрчлөлт эзэлж байна.

Хүнсний барааны жилийн инфляци -0.3 хувь байгаа бөгөөд үүний 0.3 хувийг талх, гурил, будаа, 0.2 хувийг хүнсний ногоо, -0.9 хувийг махны үнийн өөрчлөлт эзэлжээ.